МЭДЭЭ · 2022 оны 2-р сарын 1

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР Б.ЖАРГАЛСАЙХАН САР ШИНИЙН МЭНДЧИЛГЭЭ ДЭВШҮҮЛЛЭЭ



МЭНДЧИЛГЭЭ

Угтан золгож буй XVII жарны "Буян үйлдэгч" хэмээх Усан бар жилийн сар шинийн мэндийг эрхэм хүндэт прокурор, ажилтан, ахмад буурлууд Та бүхэндээ өргөн дэвшүүлье.

Цагаан сарын баяраар ураг төрлөөрөө учран золгож удам судраа мэдэлцэн, үгийн сайныг хэлэлцэн үйлсийн сайныг ярилцаж, үндэсний өв соёл, зан заншлаараа бахархдаг, эртний сайхан уламжлалтай билээ.

Ирж буй XVII жарны Усан бар жилдээ Та бүхэн минь эрүүл энх, жаргал дүүрэн, ажил үйлс тань амжилтаар арвин баялаг байхын ерөөлийг өргөн дэвшүүлье.

Сар шинэдээ сайхан шинэлээрэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН

Видео: https://www.youtube.com/watch?v=l3UNYRmNQ1o

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2338